



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/183

Бсөнбулаг

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, 2022 оны 78 дугаар тогтоол, 2023 оны 61 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Говь-Алтай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1, 2.3.1, 4.1.3 дахь зорилтуудын 2020-2024 оны хэрэгжилтийг үр дүнг олон нийтэд тайлагнах зорилгоор хийгдэж буй баримтат нэвтрүүлгүүдийг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. Шаардагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний батлагдсан зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

